

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-5

1.Дэд хороодын даргыг сонгох тухай асуудал 3-5

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
07 дугаар сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, О.Цогтгэрэл, Ө.Шижир, Л.Энх-Амгалан.

Нэг. “Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнг, Ёс зүйн дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарыг нэр дэвшүүлэв.

Нэр дэвшигчдийн танилцуулга болон нэр дэвшигчидтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Сандаг-Очир: 1.Монгол Улсын Их Хурлын Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргад М.Бадамсүрэнг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны даргад Б.Баярбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 56.5 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Сандаг-Очир: “Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 10

Бүгд: 23

56.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 13 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 71.9 хувийн ирцтэйгээр 15 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 15 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон. Байнгын хорооны хуралдаанд ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл, Аюушийн Ариунзаяа, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Баярмагнай Баярбаатар, Жудагийн Баярмаа, Сандагийн Бямбацогт, Амгаланбаатарын Ганбаатар, Тогмидын Доржханд, Сархадын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Лхагвын Мөнхбаатар, Чинбатын Номин, Нямтайширын Номтойбаяр, Эрдэнэбилэгийн Одбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун, Гончигдоржийн Уянгахишиг, Бадарчийн Хэрлэн, Доржзовдын Энхтуяа нарын 22 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргыг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл, 2.Ёс зүйн дэд хорооны даргыг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргыг сонгох тухай Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргад нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Бат-Эрдэнэ танилцуулна. Бат-Эрдэнэ даргыг микрофонд урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгуулалтын байнгын хорооны харьяа Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргад Мягмарсүрэнгийн Бадамсүрэнг нэр дэвшүүлж байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн нь 1978 онд төрсөн, эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг. Бадамсүрэн нь 1986-аас 1996 онд Чойбалсан хотын 1 дүгээр сургууль, 1996-аас 2000 онд Шинжлэх ухаан, технологийн их сургууль, 2013-аас 2015 онд Удирдлагын академийн төрийн захиргааны менежмент мэргэжлээр төгссөн. 2018-аас 2020 онд Шинжлэх ухаан, технологийн их сургуульд техникийн ухааны магистр зэрэг хамгаалсан. 2020 онд ШУТИС-ийн хүндэт профессор болсон.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн нь 2001-ээс 2002 онд Дорнод аймаг дахь Нефть хангамжийн газрын түгээгч, эрхлэгч, 2007-гоос 2009 онд Магнай трейд ХХК-ийн салбарын дарга, 2009-өөс 2012 онд Дорнод аймгийн Монгол Ардын намын хорооны дэд дарга, 2012 оноос Дорнод аймгийн Монгол Ардын намын хорооны дарга, 2014-өөс 2015 онд Дорнод аймгийн Засаг даргын орлогч, 2015-аас 2024 онд Дорнод аймгийн Засаг даргаар ажилласан. 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэнгийн Их Хуралд сонгогдон ажилласан туршлага,

төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны харьяа Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Ц.Сандаг-Очир: Бат-Эрдэнэ даргад баярлалаа. Бүсчилсэн хөгжлийн хорооны дэд хорооны даргаар нэр дэвшсэн Бадамсүрэн болоод нэр дэвшигчийн танилцуулгыг хийсэн Бат-Эрдэнэ гишүүнээс асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Санал хураалт явуулна, нэгтгээд явуулчихъя, тэгье.

Мөн Ёс зүйн дэд хорооны даргыг сонгох тухай асуудал. Ёс зүйн дэд хорооны даргад нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дарга Жадамбаагийн Бат-Эрдэнэ танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Ёс зүйн дэд хорооны дарга, харьяа Ёс зүйн дэд хорооны даргад Баярмагнайн Баярбаатарыг нэр дэвшүүлж, санал болгож байна.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар нь 1998 онд нийслэлийн 48 дугаар сургууль төгссөн. 2003 онд Шихихутаг Хууль зүйн дээд сургууль эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2012, 2021 онд Шихихутуг сургуулийн Хууль зүйн дээд сургуулийн хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. 2022 онд Монгол Улсын Их сургуульд улс төр судлалын докторант.

2003-аас 2004 онд Улсын Их Хурлын Тамгын газар, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргын туслах, 2004-өөс 2006 онд Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлын дэд даргын шадар туслах, 2006-аас 2008 онд Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлын даргын шадар туслах, 2008-аас 2011 онд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны ахлах референт, 2011-ээс 2016 онд Монгол Ардын намын Удирдах зөвлөлийн Хэрэг эрхлэх газар Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, Намын байгуулалтын хэлтэст улс төрийн ахлах мэргэжилтэн, ажилтан, 2016-аас 2020 онд Монгол Ардын намын Удирдах зөвлөлийн ажлын алба, Намын байгуулалтын газрын дарга, 2020 оноос Монгол Ардын намын Хяналтын ерөнхий хорооны дарга, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2024-өөс 2025 онд Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргаар ажиллаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатарын Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны харьяа Ёс зүйн дэд хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Ц.Сандаг-Очир: Нэр дэвшигчийн танилцуулга, нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Санал хураалт. Гишүүд санал хураалтдаа бэлдье, хуруугаа уншуулаарай. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэнг Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 23 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 56,5 хувиар дэмжигдлээ. Бадамсүрэн гишүүнд ажлын амжилт хүсье.

2 дахь санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатарыг Ёс зүйн дэд хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Би хоцорсон байна шүү. 23 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 52,2 хувиар санал дэмжигдлээ. Намайг дэмжсэн протоколд оруулаарай. Дэд хорооны дарга нарыг, Баярбаатар гишүүнд баяр хүргэе, амжилт хүсье.

“Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Дэд хорооны хороодын даргыг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10, 27.11 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэнг Бүсчилсэн хөгжлийн дэд хорооны, Монгол Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатарыг Ёс зүйн дэд хорооны даргаар тус тус сонгосугай. Тогтоолын төслийг уншиж танилцууллаа. Тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 23 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 56,5 хувиар тогтоол батлагдлаа. Дэд хорооны даргаар сонгогдсон гишүүдэд баяр хүргэж, ажлын амжилт хүсье. Дэд хорооны дарга нарыг сонгох тухай Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

15.28 цаг

Эрхэм гишүүдээ, Төрийн байгуулалтын байнгын хорооны шинээр орж ирсэн гишүүдээ цаашдаа Байнгын хорооныхоо хуралдаа идэвхтэй оролцдог, суудаг байгаарай. Улсын баяр наадамдаа сайхан баярлаарай гэж Төрийн байгуулалтын байнгын хорооноосоо хүсэж байна бүгдэд нь.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА